



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.04.25 № 25/Б УАТ-САО/2013/14/СДА-ТЭС

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ГҮЙЦЭТГЭХ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Н.ДАВГА ТАНАА

**Дуусаагүй барилга, байгууламжийг
ашиглалтад оруулах тухай**

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитаар тайлант хугацааны санхүүгийн тайланд тутгагдсан он дамжсан Чингэлтэй дүүргийн 1,306.7 сая төгрөгийн шүүхийн барилгыг ашиглалтад оруулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1.5 дахь хэсэгт зааснаар “Эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “... алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна. Үүнд:

Чингэлтэй дүүргийн 1,306.7 сая төгрөгийн барилгыг ашиглалтад оруулах талаар холбогдох арга хэмжээ авч 2013 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Н.Давга, Ерөнхий нягтлан бодогч С.Жанхор нарт хариуцуулав.

АУДИТОР

Р.ЦОЛМОН



070230